



НОГООН СУРГУУЛЬ

RAMBOLL

Ramboll Natura AB

Дугаар-01

Байгаль орчны боловсролд зориулав.

2004.12 сар



ХАМТРАН АЖИЛЛАНА

Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF)-гийн Монгол дахь Хетөлбөрийн Газраас Шведийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг (SIDA) -ийн санхүүжилтээр манай орны еренхий боловсролын сургуулиудын суралцагчад зориулан "Байгаль орчны боловсрол" дэд төслийг хэрэгжүүлж эхэллээ. Аймаг бүрээс еренхий боловсролын 4 багшийг үндэсний сургагч багш бэлтгэх сургалтанд хамруулаад байна. Тэднээр дамжуулан бусад сургуулийн багш наарт байгаль орчны боловсрол олгох сургалтыг зохион байгуулж эхэнэ.

Бага, дунд сургуулийн хичээлүүдийн агуулгад суралцагчад байгаль орчны боловсролын асуудлыг тусгах, сургалт явуулах, түүний чанар үр дүнг үнэлэхэд сургууль, багш нарын үйл ажиллагаа чиглэгдэх учиртай.

Энэ дэд төсөл амжилттай хэрэгжсэнээр багш сурагчдын байгаль орчинд хандах хандлагад өөрчлөлт гарч, эх дэлхий, ан амьтан, хөрс ургамлаа хайрлан хамгаалах төлөвшил бий болно гэж үзэж байна.

Төсөл хэрэгжүүлэгч Дэлхийн Байгаль Хамгаалах Сан(ДБХС)-гийн Монгол дахь Хетөлбөрийн Газар, БСШУЯ, БОЯ, Шведийн холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа, сургууль, багш нарын хүчин чармайлт, удирдлага, зохион байгуулалтаас төслийн үр дүн ихээхэн хамаарах болно.

**БСШУЯ-ны Бага, Дунд Боловсролын
Бодлого, Зохицуулалтын Газрын
дарга Г. Батболд**



БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛОВСРОЛЫН СУРГАГЧ БАГШ ТАНАА

Монголчууд эрт үеэс эхлэн өөрсдийгээ хөх тэнгэр эцэгтэй, хөвчин дэлхий эхтэй хэмээн, түүгээрээ бахархаж, байгаль орчно шүтэн биширч, байгаль хамгаалах уламжлалаа үр хуухэд, ач гучдаа өвлүүлэн үлдээж ирсэн сайхан уламжлалтай. Нийгмийн хөгжлийн нэг загвараас негеед шилжих, эдийн засгийн нэг хэлбэрээс негеед зохион дасах энэ эргэлтийн үед хүмүүсийн амьдралын хэв маяг өөрчлөгдэж, гэр булийн дотор залуу үедээ мэдлэг юугаа дамжуулан үлдээдэг уламжлал улам бүр бүдгэрэн орхигдож байна. Иймээс ч байгаль орчныг хамгаалах ажлыг амжилтанд хүргэх гол хэрэгслийн нэг байгаль орчны боловсролын үр холбогдол улам бүр нэмэгдэж байна.

"Тогтвортой хөгжлийн ногоон сургууль" сэдэвт танилцуулах сургалт семинарт идэвх зүтгэл, санаачлагатай оролцож буй Танд гүн талархлаа илэрхийлье.

Таныг сурч мэдсэнээ цаашид түгээн дэлгэрүүлж Монгол Улсынхаа тогтвортой хөгжлийн төлөө бидэнтэй цаашид хамтран ажиллана гэдэгт найдаж байна. Таны зүгээс сургалт семинарын зохион байгуулалт, багш нарын нэгдсэн сүлжээ байгуулах болон манай төсөлтэй холбогдолтой бусад асуудлын талаар ирүүлсэн санал хүсэлт, зөвлөмжийг ДБХС-гийн Монгол дахь Хетөлбөрийн Газар цаашид үйл ажиллагаанд тусган ажиллах болно. Монгол улсад байгаль орчны сургагч нарын чадварлаг баг бүрэлдэн тогтох, улмаар нийт багш нарын энэ талын үр чадварыг дээшлүүлэхэд багш Таны тогтвортой, идэвхтэй оролцоо хамгаас чухал байх болно.

Таныг цаашид бидэнтэй хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна. Танд ажлын өндөр амжилт хүсье.
**ДБХС-гийн Монгол дахь
Хетөлбөрийн Газрын захирал Ж. Чимэг**



"Хөдөөгийн хөгжил ба БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛОВСРОЛ" ТӨСЛИЙН ТУХАЙ

Нийт хүрээлэн буй орчныг хамгаалах үйл ажиллагаанд териин болон териин бус байгууллагууд олон жилийн турш идэвхтэй оролцсоор ирсэн. Тусгай хамгаалалттай газар нутгуудыг шинээр байгуулан ажиллуулж ирлээ. Тэгэхдээ байгаль хамгааллын бэрхшээлтэй асуудлуудыг зөвхөн байгалийн шинжлэх ухаантай холбон үзсээр ирсэн.

Харин сүүлийн жилүүдэд байгаль хамгаалах арга хэмжээний үр дүн болон нийгэм эдийн засгийн нехцел байдлын хоорондох уялдаа холбооны талаарх мэдлэг мэдээлэл нэмэгдэж төсөл, хетөлбөрүүдийг олон улсын байгууллагууд, гэрээ хэлэлцээрүүдийн дэмжлэгтэйгээр олноор нь хэрэгжүүлж ирлээ. ДБХС-гийн Монгол дахь Хетөлбөрийн Газар ч мөн дээрх чиг хандлагыг баримталж байгаа нь хэрэгжүүлж буй төслөөс нь тод харагдаж байна. "Хөдөөгийн хөгжил ба байгаль орчны боловсрол" төсөл нь энэ чиг хандлагыг бүрэн тодорхойлон бусдыг уриалан дуудсан нэг тод жишээ юм.

Энэ төслийн гол зорилго нь Хар ус нуурын байгалийн цогцолборт газрын биологийн төрөл зүйлийг хамгаалах арга хэмжээг тогтвортой хөгжлийн зүйд нийцүүлэн хэрэгжүүлэхэд оршино. Уг төсөл 2 үндсэн хэсэгтэй. Нэг нь Хар ус нуурын байгалийн цогцолборт газар болон түүний орчны бүсийн бэлчээрийн неөөцийг ашиглаж байгаа малчдын эдийн засгийн байдлын талаарх "Хөдөөгийн хөгжил" дэд төсөл, негеэ нь хойч үедээ хүрээлэн буй орчин, тогтвортой хөгжлийн талаарх мэдлэг чадварыг олгох "Байгаль орчны боловсрол" дэд төсөл юм.

"Хөдөөгийн хөгжил" дэд төсөл

Аль ч нийгэм хойч үедээ зориулан элбэг хангалуун амьдрал, баялгийг нэмэгдүүлэн бүтээхийг эрмэлздэг. Хэрвээ байгаль хамгаалах төсөл нь энэ үйл явцад саад болж байвал тогтвортой хөгжлийн асуудлууд эрсдэлд орно гэсэн

уг. Хэрэв орон нутгийн ард иргэдийн гэрт нь тулэх түлээ, идэх махгүй бол менежментийн ямар ч хэв загвартайгаас хамааралгүй аль ч хамгаалалттай газар нутагт хууль дүрэм, хязгаарлалтууд зөрчигдэх болно. Иймд ДБХС-гийн Монгол дахь Хөтөлбөрийн Газар нь олон талын идэвхтэй үйл ажиллагаа явуулж ирсэн. Бидний зорилго бол малчин ардуудтай хоршин ажиллаж, малын бус орлогын эх үүсвэрийг (байгалийн аялал жуулчлал гэх мэт) бий болгоход нь туслах, малын ашиг шимээс олох орлогыг нь нэмэгдүүлэх (малын гаралтай бүтээгдхүүний боловсруулалт, мал сүргийн чанарыг сайжруулах г.м) болон тэдэнтэй хамтран бэлчээрийн неецийг оновчтой ашиглах бодлого, загварыг боловсруулан гаргах явдал мөн. Уг дэд төсөл нь Хар ус нуурын байгалийн цогцолборт газар, түүний орчны бүсэд чиглэгдсэн болно.

Байгаль орчны боловсрол буюу тогтвортой хөгжлийн төлөөх ногоон сургууль дэд төсөл

Энэ дэд төсөл нь орон нутгийн болоод үндэсний гэсэн 2 төвшинд хэрэгжинэ. Нэгдүгээрт: Хар ус нуурын байгалийн цогцолборт газрын орчмын газар нутаг болон баруун хойд аймгуудад хэрэгжинэ. Орон нутгийн сургуулиудыг бусад сургуулиудын хувьд загвар болох жишиг сургуулиуд болгон хөгжүүлнэ. Хоёрдугаарт: Байгаль орчны боловсролын сургагч багш нарын үндэсний сүлжээг бий болгон одоогийн мөрдөгдж байгаа сургалтын хөтөлбөрт шинэчлэлт хийнэ.

Рамбол Натура (Ramboll Natura) компани

Манай компани үйлдвэрлэл, байгаль хамгааллын хосолсон төслийдийг боловсруулж хэрэгжүүлж ирсэн арвин туршлагатай. Ази, Африк, Латин Америк, Европын орнуудад ийм олон төслийдийг хэрэгжүүлсэн бөгөөд одоо Шведийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг(SIDA)-ийн санхүүжилтээр Монголд хэрэгжиж буй байгаль орчны боловсрол дэд төслийг хариуцаж байна.

Уг төслийн хэрэгжилтэнд туслалцуулахаар манай компанийг сонгосон явдалд бид гүнээ талархаж байна. Бид энэ чиглэлийн арвин дадлага туршлагатай хэдий ч төслийг хариуцан амьдрал дээр хэрэгжүүлэх хүмүүс нь Монголчууд та бүхэн өөрсдөө шүү дээ. Бид төсөл, түүний тогтвортой үр дүнг сонирхох, та бүхний сонирхолыг сэргээх үүргээ ухамсарлахад чинь тусалж чадна гэдэгтээ найдаж байна.

Бид энэ 3 жилд та бүхэнтэй хамтран ажиллахдаа урам зоригтой байна.

Төслийн багийн ахлагч Томас Херцман

БИД БҮГД НИЙЛЭЭД БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛОВСРОЛЫН ХҮЧИРХЭГ БАГ

Эрхэм нөхөд өө,

Цаг хугацаа тун хурдан нисэн одох юм. Өнгөрсөн 10 дугаар сард хийсэн сургалт семинарын үед Та бүхэнтэй уулзанаас хойш бүтэн 2 сар өнгөрчихсөн байна гэхэд үнэхээр итгэмэргүй юм. Бид ирэх оны 2, 3 дугаар сарын үед дахин уулзах болно. Энд Шведэд цаг агаар Монголынхтой ойролцоо гэхдээ тийм ч хүйтэн бус байна.

Та бүгдтэй уулзсан анхны уулзалтандаа бид маш их сэтгэл хангалуун байгаа. Бидэнд төрсөн хамгийн хүчтэй сэтгэгдэл бол бид Монголын сайн туршлагажсан багш нарын багтай болсноо мэдэрч байгаад оршино. Ялангуяа, төрөл бүрийн чиглэлээр их мэдлэг боловсрол хуримтлуулсан багш нартай учир бид бүгд нийлээд хүчирхэг баг бүрдүүлж чадна гэдэгтээ итгэлтэй байна.

Багийн зорилт нь Монгол улсын тогтвортой хөгжлийн үндэс болсон байгаль орчны боловсролыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах явдал юм. Ингэхээр боловсролын системийн зорилго нь залуу үе маань өөрсдийгээ болон нийгмийг байгальтай хэрхэн харьцах талаар шийдвэр гаргахад бэлэн байхаар хангалттай мэдээ баримт, мэдлэг чадвартай болгоход оршино гэсэн уг. Энэ зорилтыг бүх шатны сургуулиудад, бүх хичээлүүдэд, мөн албан бус сургалтын системд ч тусгасан байх нь зүйтэй.

Төсөл маань 4 зорилттой:

1. **Байгаль орчны боловсролыг өөрсдийн өдөр тутмын боловсролын үйл ажиллагааныхаа нэг**



хэсэг болгон хүргэх багш нарын чадавхийг сайжруулах сургагч багш нарын багийн идэвхтэй сүлжээг байгуулах.

2. **Бусад газруудад сайн жишээ болох бус нутгийн жишиг сургуулиудын сүлжээг баруун хойд бусийн аймгуудад байгуулах.**
3. **Орон даяар түгээх сургалтын материал, аргачлалыг цуглуулж боловсруулах.**
4. **Бусад аймгууд, сургуулиудад сайн жишээ болох орон нутгийн хөтөлбөрийг боловсруулан гаргах.**

Бидний үүрэг бол та бүхний ажлыг урамшуулан зоригжуулж төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх явдал юм. Төслийн гол хөдөлгөөгч хүч нь багш Та бүхэн юм. Зөвхөн Монголын багш нар л өөрийн улс орондоо юу хэрэгтэй байгааг шүүж чадна.

Бид өнгөрсөн семинарын үеэр та бүгдийг ямар нэг хэмжээгээр бодлогошуулж чадсан байх гэж найдаж байна. Бидний санааг гэгээн оюундаа тунгаан бодож, өөрсдийн орчин нөхцөл тохируулан бидний аргачлалыг туршиж хөгжүүлээд дараагийн семинар дээр өөрсдийн туршлагаа бусадтайгаа хуваалцана уу.

Алтай Соёны бус нутгийнхан жишиг сургуулийн багаа хэрхэн байгуулах тухайгаа, бусад аймгийнхан аймагтаа сургагч багш нарын багаа хэрхэн байгуулах тухай бусад багш нартайгаа харилцан ярилцаж, хэлэлцэхийг хүсч байна.

Сайн сайхныг хүсье!

Лейф, Страффан нар

ҮНЭ ЦЭНИЙГ ОЙЛГУУЛАХ ДАСГАЛУУДЫН АРГА ЗҮЙ, ЗААВАР

Эрдэм мэдлэгийн хүрээ улам бүр өргөжин тэлэхийн хирээр сурагчдын хувьд олж авсан мэдлэгээсээ хэрэгцээтэй нь сонгож, амьдралдаа зохиостой хэрэглэх явдал төдий чинээ бэрхшээлтэй болж байна.

Өнөөдөр бид нийгэмд биеэ авч явах байдлаа тогтвортой хөгжлийн амьдралын хэв маягт зохицуулан өөрчлөх хэрэгцээ урган гарч ирснийг ойлгодог болсон. Энэ нь олж авсан эрдэм мэдлэгтээ тулгуурлан нийгэмдээ биеэ авч явах байдлаа өөрчлөх шаардлагатай байна гэсэн уг.

Урьд нь уламжлалын дагуу мэдээллийг түгээн цацах замаар л хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг бид оролддог байлаа. Хэрэв сайн мэдээллийг л тохирсон хэмжээгээр нь цацхивал хумуус хэрэгтэйг нь аяндаа олж аваад биеэ авч явах байдалдаа ашиглах боломжтой гэсэн ойлголттой явж иржээ. Үүнийгээ батлахын тулд өөрсдийн сурагчдад биеэ хэрхэн авч явахыг нь ч зааж сургахыг оролддог байв.

Бид өндөр боловсролтой багш нарын хувьд биеэ хэрхэн авч явах нь зүйтэй гэж үзэж байгаагаараа сурагчдаа хүмүүжүүлдэг. Тэгвэл бидний үзэл бодол ийм маягаар ямагт зөв хэмээн хүлээн зөвшөөрөгдсөөр ирсний дараа сурагчид маань цаашдаа энэ хүмүүжлийн үндсэн дээр өөрсдийгээ цэнэглэж, үүнийгээ ирээдүйн амьдралынхаа хэдэн арван жилийн турш ашиглах боломжтой юу? гэсэн асуулт гарч ирж байна. Мэдээж боломжгүй зүйл. Хүчээр тулгах замаар мэдлэг, хүмүүжил олгохыг оролдох нь ямагт амжилтгүй болдог. Үүний оронд бид сурагчдаа чөлөөтэй сэтгэж өөрсдөө ямарваа нэгэн юманд дүгнэлт гаргаж сургах хэрэгтэй. Бид тэднийг сэтгэж сургавал амьдралд тохиолдох янз бүрийн бэрхшээлийг даван туулах чадвартай болж магадгүй юм.

Байгаль орчны сургалтын гол зорилго нь сурагчдыг хүрээлэн буй орчныхоо байдлыг бодитойгоор үнэлж дүгнэх, дүгнэлтэн дээрээ үндэслээд зохих арга хэмжээг боловсруулах чадвартай болгоход оршино. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд хамгийн чухал нь суралцагчид болон судлаачдад хүлээн зөвшөөрсэн хүрээлэн буй орчны талаарх сүүлийн үеийн too баримтуудыг ашиглах нь зүйтэй. Гэхдээ сургалтын явцад үндсэн зорилгодоо хүрэхийн тулд үнэ цэнэ, хандлагын үүргийг бодитойгоор мэдрүүлэх нь мөн адил чухал. Энэхүү үнэ цэнэ, хандлагын гүйцэтгэх үүргүүдийн нэг нь МЭДЛЭГИЙН ШҮҮЛТҮҮР буюу зөвхөн хэрэгцээтэй гэсэн too баримтыг шүүн, хүмүүжилд нелөөлөхүйц мэдээллийг олж аваад оршино. Иймд хамтын дасгалыг too баримт олж авах, мэдээллийг түгээх явдалтай хослуулах нь дээр дурьдсан үүргийг сурагчдад дөхөмтэй юм.

Тэгэхээр үнэ цэнэ, хандлага гэдэг нь too баримтын адилаар тогтвортой хөгжлийг заах явцад чухал нелөөтэй зүйл болох нь харагдаж байна. Сурагчдынхаа нөөц бололцоо, чадвар чадавхийг дээшлүүлэхийн тулд сургуулийн орчинг боловсронгуй болгох нь мөн адил чухал юм. 10 дугаар сард явагдсан семинарын үеэр үнэ цэнийг мэдрүүлж, ойлгуулах төрөл бүрийн дасгалуудыг давтан хийлгэсэн.

Тэдгээр дасгалуудыг бүгдийг доорх дарааллаар ижил явуулсан. Үүнд:

- Дасгалыг too баримттайгаар товч танилцуулж, шийдвэрлэх ёстой асуудлыг гаргаж тавьсан.
- Сурагчдад бодох хугацаа олгож, энэ хугацаанд бусдын нелөөнд орохгүйгээр бодол санаагаа төвлөрүүлэх боломж олгосон. ЯРИХАА TYP АЗНА, XYH БҮР ДОТРОО ШИЙДВЭР ГАРГАХ ХЭРЭГТЭЙ БАЙНА.
- Олсон санаагаа цаасан дээр буулгавал илүү үр дүнтэй. Асуулт хариултын маягаар, мөн цувруулан товч тэмдэглэх, эсвэл хэд хэдэн хувилбар гаргаж болно. Хувийн бодлоо ийнхүү бичиж тэмдэглэх нь тухайн сурагчийн хувьд дотны найз нь түүнээс өөр бодолтой байсан ч хамаагүй, өөрийн санаагаа дэвшүүлэх боломжийг олгодог.
- Одоо сурагчдыг группуудэд хуваана. Хувилбар бүрийг тэмдэглэсэн өөр өөр цаасан дээр зогсох буюу эсвэл 1-6 гэсэн өөр өөр дугаарууд дээр зогсож болно. Сургачид тухайн сонгон авсан хувилбар дээр зогссонороо өөрийн саналаа бүх биеэрээ илэрхийлэх болно. Зөвхөн ганц сургач бус бүгд асуултанд хариулна. Багуудыг хувцасных нь өнгөөр ч юмуу эсвэл өөр үзүүлэлтээр нь ижилсүүлэн бүрдүүлж болно.
- Сурагчид баг дотроо саналаа хооронд нь харьцуулна. Ижил шийдвэр гаргасан бусад нөхдийнхөө дүгнэлтийг сонсоно. Бусад сурагчид түүнтэй адил сэтгэдэг болохыг олж мэддэг. Сургач бүр гаргасан дүгнэлтээ хянаж үнэ. Бусдаасаа шийдвэртээ нэмэлт баримтуудыг олж мэдэх болно. Мөн өөртөө итгэлтэй болно. Хэрэв ямар нэг сурагчаас хувийнх нь саналыг асуувал БИ МЭДЭХГҮЙ БАЙНА гэсэн хариулт ихэнхдээ сонсогддог. Харин энэ арга зүйгээр ажиллавал өөртөө итгэлгүй, бүрэг номой сурагчдыг зоригжуулж, багийн ярилцлагын тухай илтгэх чадвартай болгож өгнө.
- Багийг төлөөлж илтгэл тавих сурагчийг сонго. Ингэхдээ ямар нэг хэмжүүрээр сонголтыг хийнэ: Жишээ нь хамгийн богино чигчийтэй, хамгийн урт үстэй эсвэл хувцсанд нь улаан өнгө хамгийн их орсон сурагчийг шалгаруулж болно. Энэ аргаар олон сургач тохиолдлоор илтгэлд хамрагдах болно.
- Илтгэгч нь багийн дотор явагдсан ярилцлагын тухай товч илтгэнэ. Энэ даалгаврыг гүйцэтгэхийн тулд сурагчид бие биенээ сонсох шаардлагатай. Өөртөө итгэлгүй сурагчдын хувьд дасгалын энэ шатанд багийнхаа доторх саналуудыг нэгтгэн товч илтгэх нь өөрийн хувийн бодол санаагаа илтгэхээс илүү хялбар байх болно.
- Бүх багууд илтгэлээ тавьсны дараа чөлөөт ярилцлага маргааныг нийтийн дунд өрнүүлнэ. Сургач бүр өөрийн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой.

Уг дасгалыг удирдан хийлгэж байх үед ангийн багшийн хувьд санаа бодлыг тань сонирхон асууж болох юм. Тэгвэл та өөрийн байр сууриа шууд тодорхой хэлж болохгүй, учир нь сурагчдын хувьд тэдний бодол таныхаас зөрж

байвал өөрсдийгээ буруу бодсон байна гэж үзэхэд хүрнэ. Тэгвэл энэ дасгал маань эргээд сурагчдаас багшийнхаа саналыг таах дасгал болон хувирч болзошгүй. Энэ нь сурагчдыг өөрсдөө бодож сэтгэхэд сургах таны зорилгод аюул учруулж харшилна.

Эдгээр дасгалуудад зөв, буруу байхгүй, зөвхөн янз бүрийн саналуудыг гаргаж дэвшүүлэх зорилготой. Сурагчдыг бусдын төрөл бүрийн бодол санааг ойлгож, хундэтгэхэд сургах нь маш чухал юм.

Маргаан бол хэзээ ч дуусдаггүй. Тус дасгалын зорилго нь нэгдсэн нэгэн дүгнэлтэд хүрэх бус сурагчдыг чөлөөтэй сэтгэж, өөрөөрөө байж, түүийгээ илэрхийлж, бусад нөхдийнхөө яриаг сонсож сургахад оршино. Энэ аргыг байгаль орчны сургалтын ардчиллын үндсэн курс хэмээн нэрлэж болно.

Ерөнхийдөө дасгалууд асуултуудад нь хариулах хариултын тооноосоо давсан олон асуултуудыг ургуулан гарган ирдэг. Ямар гайхамшигтай зарчим бэ? Тэгвэл сургчид асуултаа тавьж та өөрөө багшийн хувьд хариулт өгч болно шүү дээ.

Лэйф, Страфан нар

Дасгал 1. ИРЭЭДҮЙН ТУХАЙ ТӨСӨӨЛЛИЙН 4 ХУВИЛБАР БУЮУ 4 ЭРХЭМ ЗОРИЛГО

Ирээдүйн тухай өөрсдийнхөө үзэл бодолтойгоо ажиллах нь чухал байдаг. "Алиса гайхамшигийн оронд" гэдэг хуүхдийн алдарт номонд энэ тухай Алиса "Хаана очихоо мэдэхгүй байгаа бол бид замаа алдаж төөрөх нь мэдээж" гэсэн байдаг. Гэхдээ бид ирээдүйд хаана хүрэх чиглэлээ сонгож чадна. Ирээдүйг бид ямраар төсөөлж, ямар байлгахыг хүсдэг вэ? 25 жилийн дараах үеийг толгойдоо төсөөлэн 1 дасгал ажиллаад үзье. Энэ дасгал ирээдүйн тухай 4 янзын хувилбартай.

Дасгалын заавар:

- Ирээдүйн тухай 4 төсөөллийн талаар доороос уншина уу. Тухайн хувилбар ирээдүйд "тохиолдох байх" эсвэл "тохиолдохгүй байх" гэж бодож байгаагаа 1-р шулуун дээр зохих дугаараар тэмдэглэнэ үү. Тухайн ирээдүйн хувилбарыг "тохиолдоосой" эсвэл "бүү тохиолдоосой" гэж хүсэж байгаагаа 2-р шулуун дээр тэмдэглэнэ.
- Дараа нь ирээдүйд юун түрүүнд тохиолдож болзошгүй гэж бодож байгаа хувилбар(1-4-н аль нэг)-ийн гарчгийн доогуур зурна уу.
- Ирээдүйд тохиолдоосой гэж хамгийн их бодож байгаа хувилбараа "х"-р тэмдэглэнэ үү.

1. Аюулыг хэтрүүлэн төсөөлж байжээ

Шинэ мянган гарах үед уур амьсгалын талаар төсөөлж байсан асар том аюул аз болоход тохиолдсонгүй. Орчин үеийн технологиор нүүрсхүчлийн давхар ислийг далайн усанд уусгадаг болсноор дэлхийн агаар мандалд ялгарах хорт хийн хэмжээ XX зууны үеийнх шиг байхаа больсон байна. Ингээд хатуу түлш нь шинэ технологийн эрчим хүчиний эх үүсвэр болов. Түлшний эсийн дотоодод цахилгаан эрчим хүч болон хувирч чадах устэрэгчийн хийг нарны энергийн тусламжтайгаар их хэмжээтэйгээр гарган авсан. Тээврийн хэрэгслэлийн ихэнх нь устэрэгч хийн түлшээр ажиллаж байна. Хайлшаас энерги гарган авах технологи нь эрчим хүчиний технологийн хамгийн суулчийн ололт

болоод байгаа. Устэрэгчийн атомуудыг уснаас ялган авч, нэгдүүлэх урвалаар асар их хэмжээний эрчим хүч үйлдвэрлэх боломжтой. Энэхүү шинэ технологийн ачаар хүн төрөлхтөн эрчим хүчиний хомсдолоос чөлөөлөгдөв. Дэлхий дээр эрчим хүчиний хомсдол байхыг болилоо.

Тийм зүйл тохиолдоно.					
1	2	3	4	5	6

Тохиолдоосой					
1	2	3	4	5	6

2. Тохиолддогоороо тохиолдлоо

ХХ зууны сүүлээр эрдэмтэд дэлхийн агаар мандалд ялгарч байгаа нүүрсхүчлийн давхар ислийн хэмжээг бууруулахгүй бол дэлхийн цаг уур өөрчлөгдхөх аюулын талаар анхууруулж байсан. Бензин, нүүрсний хэрэглээ багассангүй харин нэмэгдсэн.

Дэлхийн улс орнууд зөвхөн өөрсдийн эрх ашгийг бодож аж үйлдвэрийн салбарууд богино хугацааны санхүүгийн эрх ашгаа л хөөцөлдөнө. Энэ бүхэн буруу байсан нь нотлогдов.

Уур амьсгалын өөрчлөлт эрдэмтдийн тооцоолж байснаас илүү өргөн болж урьд өмнө байгалийн гамшиг болж байгаагүй газруудад ч ган гачиг, үер ус, салхи шуурга газар авав. Хоол хүнсний үйлдвэрлэл ч мөн адил өртөв. Хоол хүнсээр элбэг дэлбэг байсан газруудад хүнсний хомсдол үүсвэв.

Дэлхийн эдийн засагт хамрал нүүрлэв. Нийтийн мэдээллийн хэрэгслэлүүдээр хамралын тухай мэдээ дүүрлээ.

Дээрхийн адил зүйл тохиолдохгүй.	Тийм зүйл тохиолдоно.
1 2 3 4 5 6	

Бүү тохиолдоосой	Toхиолдоосой
1 2 3 4 5 6	

3. Зарим ололт зарим алдагдал

Дэлхий өртөнц хамралд ороод байна. Ган гачиг, үер ус, салхи шуурга олон улс оронд асар их хэмжээний эвдрэл сүйрэл учруулаад байна. Байгалийн ослын шалтгаан нь хатуу тулш ашиглах явдал эрс нэмэгдсэнтэй холбоотой. Ган гачигаас үүдэлтэй байгалийн гамшигаас дүрвэгсдийн цуваа бий болов.

Газар тариалан, ойгоос олдог үйлдвэрлэл нь халуун, хуурай уур амьсгалаас болж хязгаарлагддаг ядуу буурай орнуудад байдал бүр ч муу байна.

Хүйтэн цаг уурын улмаас үйлдвэрлэл нь хязгаарлагдмал байсан, өмнө нь харьцангуй баялаг хуримтлуулсан умард зүгийн улс орнуудын ашиг орлого цаг уурын дулааралтын улмаас нэмэгдэв. Эдгээр улсуудад газар тариалан, ойн аж ахуйн үйлдвэрлэл өсөн нэмэгдэж байна.

Эдгээр улс орон уур амьсгалын өөрчлөлтийн хор уршгийг даван нөхөх эдийн засгийн чадавхтай болсон байна.

Дээрхийн адил зүйл тохиолдохгүй.	Тийм зүйл тохиолдоно.
1 2 3 4 5 6	

Бүү тохиолдоосой	Toхиолдоосой
1 2 3 4 5 6	

4. Бялтууны булан

Мөхлийн өдрүүдийн талаарх таамаглал буруу байжээ. Тогтвортой өсөлт эдийн засгийн өрсөлдөөнд давуу тал авчрахыг худалдаа, үйлдврийн салбарынхан ойлгосноор нүүрсхүчлийн давхар ислийн ялгаруулалт шинэ мянганы эхэнд дэлхийн улсуудын засгийн газруудаас шаардсан хэмжээгээр ихээхэн буурав.

Эрчим хүчний ухаалаг технологийн ачаар хэрэглээ нь мэдэгдэхүйц буурч нарны эрчим хүчний салбарт технологийн асар том үсрэлт гарав. Газрын тосыг одоохондоо байгалийн полимер материалыар орлуулж чадаагүй байгаа тодорхой тооны хуванцарыг л үйлдвэрлэхэд ашиглах болсон байна.

Хүмүүс өөрсдийн жинхэнэ байдлаар аж төрж эхлэв. Улс төрийн тавцанд урьдынхаас өөр үнэ цэнэ бүхий улс төрийн намууд давамгайлах болов. Шинэ зорилтуудын дагуу дэлхийн байгалийн баялгийн хэрэглээ өнөөдөр байгаа хэрэглээний өчүүхэн хэсэг хүртлээ буурсан байна.

Дээрхийн адил зүйл тохиолдохгүй.	Тийм зүйл тохиолдоно.
1 2 3 4 5 6	

Дасгал 2. Асуултуудад хариулахдаа тохирох хариултыг дугуйлна уу.

1. Манай улсын тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэхэд ямар хүчин зүйл хамгийн чухал вэ?

1. Орчин үеийн шинэ технологи?
2. Хариуцлагатай улс төрчид?
3. Хөгжсөн хүчирхэг эдийн засаг.
4. Хүмүүсийнх нь мэдлэг.

2. Монгол улсын нийгэм хир тогтвортой хөгжиж байна вэ?

1 2 3 4 5 6	Их биш	Их!
--------------------------------------	--------	-----

3. Байгаль орчноо сайжруулахын тулд Таны зүгээс хувь хүний хувьд юу хийж чадах вэ?

1. Байгаль орчны чиглэлийн төрийн бус байгууллагатай хамтарч ажиллаж эхлэх!
2. Улс төр рүү орох!
3. Бусдад сайн үлгэр жишээ болохуйцаар амьдрах.
4. Байж болох бусад хувилбарууд:

4. Монгол улсын хувьд байгаль орчны хамгийн чухал асуудал юу болоод байна?

1. Бэлчээрийн менежмент
2. Байгалийн нөөцийн хэрэглээ
3. Усны нөөц
4. Уур амьсгалын өөрчлөлт
5. Хэрэглээний шинэ хэв маягийг гарган хөгжүүлэх

5. Дараахь өгүүлбэрүүдийг гүйцээж бичнэ үү.

Байгаль орчиндоо хариуцлагатай ханддаг хүн гэдэг нь
.....

Байгаль орчинд сайнаар оруулах миний хувь нэмэр нь
.....

Манай гэр бүл дараах маягаар хувь нэмрээ оруулна
.....

Хэрвээ би аймгийнхаа дарга болбол

.....
.....

6. Хамгийн чухал гэж бодож байгаа асуудлуудаа доорх хүрээний дотор талд бичнэ үү.

Манай аймгийн хамгийн чухал байгаль орчны асуудлууд юу вэ?

.....
.....
.....
.....

ЦӨЛЖИЛТИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Дэлхийн хуурай газрын 34% буюу 48.8 сая ам дөрвөлжин км талбайг гандуу ба гандууттар бус нутаг зээлдэг. Гандуу хуурай нутаг х.е. 15-45°, ё.е. 13-22°-ын хооронд үндсэндээ тархсан байх бөгөөд эдгээр бус нутгийн зарим хэсэгт цөлжих үйл явц эрчимтэй явагдаж байна. Энэ бус нутгуудад дэлхийн хамгийн алдартай цөлүүд, тухайлбал, Ази тивд Каракум, Кызылкум, Такла-Макан, Алашань, Алтайн евер говь, Тар, Дештепут, Деште-кевир, Их, Бага Нефуд, Сирийн цөл, Африк тивд Их сав, Сонар, Атакан, Сечур, Патагон, Австрали тивд Элсэн цөл, Гибсон, Симпсон, Викторын цөлүүд оршдог. Эдгээр цөл нутгийн нийт талбай 9 сая км² орчим юм.

Одоо дэлхийн бөмбөрцгийн дөрөвний нэг хувь буюу 38 сая ам дөрвөлжин км талбай бүхий нутаг цөлжиж дэлхийн 100 орчим оронд цөлжилтийн асуудал хурцаар тавигдах боллоо. Эдгээрээс Алжир, Египет, Ливи, Нигер, Мавритани, Судан, Мали, Оман, Саудовын Араб, Йордан, Йемен, Бахрейн зэрэг Ази, Африкийн 24 орны нутаг бараг цөл болсон буюу цөлжилтэд хүчтэй автаад байна. Энэ бус нутагт жил бүр 60 мянган ам км талбай цөлжилтэд нэрвэгдэн аж ахуйн эргэлтээс гарч байна гэсэн тооцоо бий.

Цөлжилтийг зэрэглэлээр нь авч үзвэл дэлхийн хэмжээнд нийт цөлжсен нутгийн:

- 41.3% сул,
- 45.2% дунд зэрэг,
- 12, 6% хүчтэй,
- 0.7% хүчтэй цөлжилтэнд нэрвэгдсэн байна.

Нийт газар тариалангийн 70%, нийт бэлчээрийн 73% нь эзэгдэлд орсон байна. Ялангуяа Африк, Хойд Америкт газар ихээхэн эзэгдэлд орсон байна. Нийт эзэгдэлд орсон газрын 45.2% нь усны нөлөөгөөр, 41.8% нь салхины нөлөөгөөр, 9.7% нь химиин бодисын нөлөөгөөр, 3.4% бусад шалтгааны улмаас эзэгдэлд орсон байна. Цөлжилтийн 34.5% нь малын бэлчээр талхлагдалт, 29.5% нь ойг отлож, сүйтгэсэнтэй, 28.1% газар тариалан эрхлэлттэй холбоотой байдаг байна.

НҮБ 1977 онд анх Кени улсын нийслэл Найроби хотод цөлжилтийн асуудлаар олон улсын бага хурал зохион байгуулж уг хурлаас цөлжилттэй тэмцэх дэлхий нийтийн стратегийг боловсруулж холбогдох тунхагийг гаргасан. Үүнээс хойш НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Байгаль орчны хөтөлбөр, ЮНЕСКО-гийн "Хүн ба шим мандал" хөтөлбөр, Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллага зэрэг олон улсын төрөлжсөн байгууллагын хүрээнд ихээхэн анхаарал тавьж дэлхийн янз бүрийн бус нутагт төсөл, хөтөлберүүд хэрэгжүүлсээр байгаа билээ.

Desertification буюу "desert" fication" гэдэг англи үгийг үг зүйн хувьд авч үзвэл цөл бий болгох гэсэн утга санааг илэрхийлдэг байна. Цөлжилт бол удаан хугацаагаар үргэлжлэх газар дорийтох үйл явц, цөл бол энэ үйл явцын төгсгөлийн үе шат гэж үздэг. Цөлжилт нь байгалийн болон хүний үйл ажиллагааны олон цар хүрээт үйл явцын үр дунд явагддаг учраас цөлжилтийн нийтлэг нэгдсэн тодорхойлолт гаргахад нилээд хүндрэлтэй юм. Судлаачид өөр өөрийн шинжлэх ухааны салбар, үзэл баримтлал, асуудлыг яаж тавьж, хэрхэн хандаж буй зэрэгээс шалтгаалан цөлжилтийн олон тодорхойлолт гаргасан байдаг.

1994 онд НҮБ-ын цөлжилттэй тэмцэх конвенцийн газраас "Ур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааг хамруулан олон янзын хүчин зүйлийн нөлөөгөөр хуурай, хагас хуурай, хуурайвтар, чийг дутмаг нутагт газар орчин дорийтохыг цөлжилт гэнэ" гэж өнөөдөр мөрдөж буй цөлжилтийн тодорхойлолтыг гаргажээ.

Манай орны хувьд ган, цөлжилтийг хамгийн нийтлэг утгаар нь авч үзвэл хур тунадас, ус чийг дутагдсаны улмаас хэсэг хугацаагаар бэлчээрийн гарц муудахыг ган, үг үзэгдэл удаан хугацаагаар тогтвортой үргэлжлэн газар дорийтолд орохыг цөлжилт гэнэ. Гэхдээ нийгмийн ба хүний хүчин зүйлсийн нөлөө их гэдгийг харгалзан үзвэл цөлжилт гэдэг нь байгалийн хүчин зүйлс ба аж ахуйн үйл ажиллагааны нөлөөгөөр гандуу хуурай нутгийн экосистем алдралд орж, биологийн бүтээмж нь хомсдон эцсийн дунд тухайн нутгийн байгаль, эдийн засгийн хүчин чадавх буурах таагүй үзэгдэл юм.

Цөлжилт нь дараах динамик үйл явцын өөрчлөлтөөр тодорхойлогоно.

1. Ур амьсгалын (макро, микро уур амьсгал өөрчлөгдсөнөөр хаталт гандалт ихсэх, усны нөөц

- хомсдох, хур тунадас тогтмол биш болох зэрэг)
2. Гидрогеологийн (гүний усны тэжээл өөрчлөгдөх, түвшин доошлох зэрэг)
 3. Морфодинамикийн (давсны өгөршил, ус салхины элэгдэл, эвдрэл идэвхтэй явагдах, ургамалжсан элс хөдөлгөөнт элс болж хувирах зэрэг)
 4. Хөрсен бүрхэвчийн (хөрс хагсах ба давсжих)
 5. Ургамал нэмрэгийн (ургамал нэмрөг алдрах)
 6. Амьтны аймгийн (амьтдын зүйлийн бүрэлдэхүүн өөрчлөгдөх, тоо толгой хорогдох зэрэг).

Эдгээр үйл явцын өөрчлөлт нь цөлжилтийн эрч хүчийг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэх ба эдгээрт хүн ам, малын нягтшилт, аж ахуйн ажлын механикуулалт давхар нөлөөлне.

ШУА-ийн Газарзүйн хүрээлэн анх удаа Монгол оронд цөлжилтийн судалгааны эхлэлийг тавьж улмаар 1986-1990 онд Туркмен улсын Цөл судлалын хүрээлэнтэй (хуучин нэрээр) "Цөлжилтийн үйл явцыг судалж гандуу нутгийн экосистемийг зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээ боловсруулах" төслийн хүрээнд хамтарсан судалгаа явуулж, цөлжилтэд нөлөөлөх үндсэн хүчин зүйлүүдийг тодорхойлох шалгууруудыг монгол орны нөхцөлд тохируулан боловсруулж, гандуу нутгийн литозэдаф хэвшинж, ландшафт, цөлжилт, байгаль хамгааллын цуврал зургууд зохиож цөлжилттэй тэмцэх нэгдсэн арга хэмжээг боловсруулж, цаашдын хандлагад үнэлгээ егсен юм.

ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн өөрийн харьяндаа 1997 оноос цөлжилтийн чиглэлээр судалгаа явуулах, төсөл хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй "Цөлжилтийн судалгааны төв"-ийг байгуулан ажиллуулж ирлээ. Тус төвийн ажилтнууд энэ хугацаанд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс санхүүжүүлсэн "Замын үүдийн цөлжилттэй тэмцэх, газрын менежментийг боловсронгуй болгох" төслийг амжилттай хэрэгжүүлсэн байна. Төслийг хэрэгжүүлснээр Замын үүд сумын төвийн цөлжсөн учир шалтгааныг судлан тогтоож, цаашид газар, ус, бэлчээрийн менежментийн чиглэлээр авах арга хэмжээг тодорхойлон холбогдох зөвлөмж боловсруулж тус сумын захиргаанд шилжүүлэв. Мен элсний нүүлтээс хамгаалах ногоон бүсийн зураг төсөл боловсруулж улмаар уг бүсэнд 26000 мод бут тарьж ургууллаа. Нутгийн оршин суугчдад цөлжилттэй тэмцэх арга ухаан болон мод тарьж ургуулах талаар хэд хэдэн удаагийн сургалт зохион байгуулав.

Тус төвөөс "Говь, хээрийн бүсийн цөлжилтийн аюулыг сааруулах шинжлэх ухаан, технологийн үндэслэл" төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн цөлжилт эрчимжсэн Баяндэлгэр, Наан, Онгон, Дарьганга сумдын нутагт цөлжилтийн төлөв байдлыг тогтоох, зураглах, Онгон, Молцог элсийг ургамалжуулах, доройтсон баянбүрд, булаг шандыг сэргээх чиглэлээр үндэслэл боловсруулан захиалагч байгууллагад шилжүүлээд байна.

Б. Энхцэцэг, ДБХС- гийн

Монгол дахь Хөтөлбөрийн Газар

Д. Даш, ШУА-ийн Гео-экологийн хүрээлэн

БИДЭНД ЗАХИДАЛ ИРЛЭЭ.

Бидэнтэй семинаруудын хооронд холбоотой байж, өөрсдийн арга ажиллагааны талаар захидал ирүүлсэн дараах багш нартав баярлалаа. Орхон аймгийн байгалийн ухааны гүнзгийруулсэн сургалттай 10 жилийн 14-р сургуулийн биологийн багш С. Цогбадрах, Орхон аймгийн Жаргалант сумын 10 жилийн сургуулийн биологийн багш У. Нямцэцэг, Завхан аймгийн Улиастай сумын Дэвшил сургуулийн сургалтын менежер Д. Отгонжаргал, Баянхонгор аймгийн Жаргалант сумын 10 жилийн сургуулийн багш Б. Оюундарь, Баян-Өлгий аймгийн 3-р 10 жилийн сургуулийн багш Х. Данагүл нараас бидэнд захидал ирүүлж "Байгаль орчны боловсрол" төслийн талаарх өөрсдийн сэтгэгдэл, санаа бодол, танилцуулах сургалт семинараар сурсан мэдсэнээ өөрсдийн сурган хүмүүжүүлэх үйлстээ хэрхэн нэвтрүүлж байгаа талаар мэдэгдсэн явдалд чин сэтгэлээсээ талархаж байна.

Танилцуулах сургалт семинарын дараа багш Б. Оюундарь өөрийн сургуулийн багш нарт 4 цагийн сургалт, багш Х. Данагүл сургуулийнхаа нийт 40 багшид 1 өдрийн сургалт тус тус зохион байгуулсан байна. Дэвшил сургуулийн сургалтын менежер Д. Отгонжаргал экологийн хичээл заадаг багш нарыг оролцуулаад сургуулийнхаа бүх багш нарт семинарын тухай танилцуулж сургалтын олон хэлбэр ашиглаж болохыг заалаа. Орхон аймгийн биологийн багш С. Цогбадрах захидалдаа тус сургуулийн захирал А. Сэлэнгэбаатар төслийн хүрээнд хийгдэж буй ажлыг дэмжиж орон нутагт газар дээр нь хэрэгжүүлэх ажилд сургуулийн захиргааны зүгээс бүрэн дэмжих боломжтой гэснийг уламжилжээ.

Орхон аймгийн Жаргалант сумын 10 жилийн сургуулийн биологийн багш У. Нямцэцэгийн захильтыг доор сийрүүлэн та бухэнд толилуулж байна.

"Хөдөөгийн хөгжил ба байгаль орчны боловсрол" төслийн хүрээнд зохион байгуулагдсан "Тогтвортой хөгжлийн ногоон сургууль" сэдэвт танилцуулах сургалт семинаарт оролцсондоо түйлэн баяртлай байгаагаа илтгэхийн дашрамд цаашид хамтран ажиллаж, та бүхнээс их зүйл сурч, түүнийгээ бусдад түгээх, багш нарын нэгдсэн сүлжээ байгуулах ажилд өөрийн боломж хүч чадлаа дайчлан, тогтвортой идэвхтэй ажиллахаа амлаж байна.

"Тогтвортой хөгжлийн ногоон сургууль" сэдэвт сургалтыг Жаргалант сумын 10 жилийн дунд сургуулийн 29 багш нарт, Жаргалант сумын ЗДТГ-ын ажилласад, ард иргэд 20 хүнд, Орхон аймгийн биологийн багш нарт, Жаргалант сумын 10 жилийн сурагчдын төлөвлөгчдөд зориулж явуулсан байна. Сургууль дээр нь Сакура бүлгэм байгуулагдан ажиллаж байгаа, "Эрүүл орчин бидний хэрэглээ" сэдэвт ажлын хүрээнд ургацын баярыг зохион байгуулж эцэг эхээс өндөр үнэлэлт авч, орон нутгийн төлөвийн зэрэгцээ цацуулж ард иргэдэд сурталчилсан тухайгаа бичижээ.

Тэрээр мөн семинарын олопттой талын тухай сэтгэгдэлдээ сургалт семинарыг зохион байгуулсан Шеед багш нарын заах арга, онолын мэдлэг сайн, бусдыг өөртөө татах увидастай, хичээлийг сонирхолтой явуулж байсан. Дээрх багш нарын заах арга зүйг орон нутгийн багш нарт сургалт явуулаадаа ашигласан нь их өндөр сэтгэгдэл төрүүллээ.

Бэрхшээлтэй тал нь тухайн хичээл явуулахад шаардлагатай мэдээ материалаыг олж авах, сурагчдад ойлгомжтойгоор эмхлэн цэгцэлхэд их цаг шаардсан. Тухайн сурагч бурийн гар дээр тавих тарааж өгөх материалын бэлдэхэд бичгийн цаас их хэмжээтэй хэрэг болсон нь хичээл бурийг тогтмол иймэрхүү аргаар явуулахад бэрхшээлтэй байсан. Канон, компьютерын хүрэлцээ муу байгаа нь хичээлийн бэлтгэл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлсэн... гэжээ. Бидэнд захидал бичсэн та бухэнд баярлалаа. Та бухэнд амжилт хүсье.

"Тогтвортой хөгжлийн ногоон сургууль" сэдэвт танилцууллах сургалт, семинарын цед авсан зургуудаас толилуулж байна.



**Дэлхийн Байгаль Хамгаалах Сан(WWF)-гийн
эрхэм зорилго нь эх дэлхийн байгаль орчны доройтлыг
зогсоож, хүн төрөлхтөн байгальтайгаа харилцан
шүтэлцэж амьдрах ирээдүйг бүтээхэд оршино.**

ДБХС-гийн Монгол дахь
Хөтөлбөрийн Газар
Ус Цаг Уурын Хүрээлэн,
Худалдааны гудамж-5, өрөө № 309, 312
Улаанбаатар 46, Монгол Улс

Утас: +976-11-311-659
Факс: +976-11-310-237
Э-майл: wwfmon@magicnet.mn
Вэб: www.wwf.mn



For a living planet®

Дугаарыг бэлтгэсэн: Б. Болормаа
Хянасан: Н. Батнасан
Д. Дондог
Хэвлэлийн эх бэлтгэсэн: ТОМОТ

